



**НИЙСЛЭЛИЙН
АХМАДЫН ХОТХОН-1 ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 01 сарын 17 өдөр

Дугаар А/05

Улаанбаатар хот

Хөрөнгө худалдаж авах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 20.1.10 дахь заалт, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.2, 17.2.4 дэх заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалт, 27 дугаар зүйлийн 27.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Монгол улсын Засгийн газрын 2013 оны “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 68 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ажилчдын хөдөлмөрийн нөхцөл, эрүүл ахуйн шаардлагыг сайжруулах, авто гараашийн галын аюулгүй байдлыг хангахад зориулж худалдан авах бараа материалын төсвийг хавсралтаар баталсугай

2. Бараа материал худалдан авахад шаардагдах 1.282,500 /Нэг сая хоёр зуун наян хоёр мянга таван зуун/ төгрөгийг зохих зардлаас гаргахыг Нягтлан бодогч /С.Баяржаргал/-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтийг хангуулж ажиллахыг Дулааны инженер /Г.Чулуунбаатар/-т даалгасугай.


ДАРГА



Ц.ОТГОНБАТ

1140300009

“Ахмадын хотхон-1” орон нутгийн өмчит
аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын
даргын 2019 оны 01 дүгээр сарын 17-ны
өдрийн 4/15 дугаар тушаалын хавсралт



БАРАА МАТЕРИАЛЫН ТӨСӨВ ТООЦОО

№	Бараа, материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1.	Галын хор (4кг) цэнэглэх	ш	20	14400	288000
2.	Галын хор (2кг) цэнэглэх	ш	5	9900	49500
3.	Галын хор (4кг)	ш	10	35100	351000
4.	Галын хор (2кг)	ш	10	24200	242000
5.	Хувцасны шкаф (6 хаалгатай)	ш	1	352000	352000
Нийт					1282500